



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2025 оны эхний хагас жилийн тайлан

Хонх нь дуугарвал дамар нь таг...

Хонх нь дуугарвал дамар нь таг...

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй, нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 хувиар нэмэгдлээ. Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү авчээ. Эдийн засгийн салбаруудын сэргэлтэд банкны олгож буй зээл чухал нөлөөтэй байна. Тухайлбал, бизнесийн зээл тэр дундаа боловсруулах, барилга болон худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн хэмжээ огцом нэмэгджээ. Инфляц аажмаар буурч, иргэдийн төгрөгт итгэх итгэл хэвээр байгаа нь төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд нөлөөлжээ.

Эхний хагас жилд эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай гарсан. Удаан хугацааны дараа ХАА-н салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна. Барилга, боловсруулах салбар өсөлттэй байгаа нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлжээ. Уул уурхайн салбар хүлээлтээс доогуур байсан нь тус салбарыг дагасан худалдаа, тээврийн салбарт сөргөөр нөлөөлж эдийн засгийн өсөлтийг хойш нь татлаа. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалан экспортын хэмжээ буурсан нь төгрөгийн ханшид дарамт үзүүлж байна. Төгрөгийн бодит ханш суларч байгаа нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна.

Төсвийг боловсруулахдаа гадаад, дотоод эрсдэлт хүчин зүйлсийг сайтар тооцож төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж, бодит эдийн засгийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллахгүй бол “Хонх нь дуугарвал дамар нь таг” гэдэг шиг нөхцөл байдал руу шилждэг тогтолцоотой болох нь.




Иргэдэд олгох хэрэглээний зээл буурч байна.

Хадгаламж барьцаалсан зээл 26 хувиар нэмэгджээ. Малчдад олгосон зээл 40 хувиар нэмэгджээ. Харин цалин, тэтгэврийн зээл 30 хувиар буурчээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн II улирал



Онолын тодорхойлолт

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

-4%

2024 оны II
улирлын гүйцэтгэл

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын бизнесийг дэмжихэд чиглэсэн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.



Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ буурчээ.



Хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжиж байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Банкуудын хувьцааны ханш харьцангуй тогтвортой өсөлттэй байна.



Банкуудын хувьцааны өгөөж хадгаламжийн өгөөжтэй тэнцүү байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна.


Эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээл олголт нэмэгджээ. Иргэдийн хэрэглээний зээл буурч эхэлжээ.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+27%

Зээлийн үлдэгдэл өсөв.




Эдийн засгийн салбаруудыг дэмжсэн бизнесийн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Уул уурхай, боловсруулах, барилга болон худалдааны салбарыг дэмжсэн зээл олголт өндөр байна. Үйлчилгээний салбарт олгох зээл олголт буурчээ.

Тэрбум ₮

Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр бизнесүүдэд олгосон зээл

19%

нэмэгджээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ

5%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ буурчээ.


Цалин, тэтгэврийн зээл болон автомашины зээлийн чанаргүйдэл нэмэгджээ.

Эдийн засгийн салбарууд харьцангуй өсөлттэй байгаа нь бизнесийн зээлийн чанаргүйдэл буурахад нөлөөлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал




Эх үүсвэр хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжиж байна.

Төгрөгийн ханш суларч буй хэдий ч иргэдийн төгрөгт итгэх итгэл өндөр байгаа нь төгрөгийн хадгаламж 15 хувиар нэмэгдэхэд нөлөөлжээ.

Валютын хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжиж байна.

Банкны эх үүсвэр, жил бүрийн II улирал

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

15%

НЭМЭГДЖЭЭ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү


17%

Эх сурвалж: Монголбанк

Хүү тогтвортой байна.

Гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бодлогын хүүг өсгөсөн хэдий ч хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.

Эдийн засаг тогтворжиж буй нь зээлийн хүү аажмаар буурах хүлээлтийг үүсгэлээ.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


15%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 8.5 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ-ны актив 23 хувиар, Голомт банкны актив 22 хувиар, Хас банкны актив 20 хувиар тус тус өсжээ. Төрийн банкны актив 10 хувиар, Хаан банкны актив 8 хувиар тус тус нэмэгджээ.

Банкуудын актив, жил бүрийн II улирлаар харуулав.




Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Голомт банкны эх үүсвэр 22 хувиар, ХХБ-ны эх үүсвэр 15 хувиар тус тус нэмэгджээ.

Харин Хаан банкны эх үүсвэр 5 хувиар буурчээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн II улирал



2023	2024	2025
Хаан		
ХХБ		
Голомт		
Төрийн банк		
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

7%

НЭМЭГДЭВ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж

11%


Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөжийн дундаж хадгаламжийн өгөөжтэй тэнцүү байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 6.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсжээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн II улирал

Хувиар




Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурч буй хэдий ч хангалттай хэмжээний зээл гаргах хөрөнгөтэй байна.

Эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг хурдасгахад чиглэсэн зээлийн өсөлт нь банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг буурахад нөлөөлжээ.

Иргэдэд зориулсан хэрэглээний зээл олголт буурч байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн II улирал



2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж


36%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа буурч байгаа ч хөрвөх чадвар өндөртэй байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн II улирал



2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН, ТӨЛӨВ

2025 оны эхний хагас жил: Эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай гарлаа. ХАА-н салбар удаан хугацааны уналтын дараагаас огцом сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Боловсруулах болон барилгын салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Уул уурхайн салбар нь хүлээлтээс доогуур өссөн бөгөөд түүнийг дагаад тээвэр, агуулахын салбар удааширч эдийн засгийн өсөлтийг хойш татаж байна. Эрэлтийн талаас нь харвал хэрэглээ болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн нь эдийн засгийн сэргэлтийг дэмжсэн бол экспортын хэмжээ багассан нь өсөлтөд сөрөг нөлөө үзүүлжээ. Эрэлтийн талын инфляцын түвшин буурч байна.


Төлөв байдал: Оюу толгойн олборлолт түүхэн дээд хэмжээнд хүрээд байна. Цаашид гүний уурхайн олборлолт, түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, үүнийг дагаад экспортын хэмжээ нэмэгдвэл эдийн засгийн өсөлт үргэлжлэх хүлээлтийг бий болгож байна. БНХАУ нүүрсний олборлолтондоо хязгаарлалт тавиад байгаа нь манай улсын нүүрсний үнэ нэмэгдэхэд эергээр нөлөөлөх дүр зургийг бий болгож байна.

2024 оны эхний хагас жилд эдийн засаг 5.6 хувиар өсөв.

ХАА-н сэргэлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Боловсруулах болон барилгын салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүллээ.

Уул уурхайн салбар хүлээлтээс доогуур өсөлттэй байсан нь уул уурхайг дагасан тээвэр, худалдааны салбарт нөлөөлж эдийн засгийн өсөлтийг хойш татлаа.



Гадаад худалдааны ашиг 58 хувиар буурчээ.

Нүүрс болон төмрийн хүдрийн тоо хэмжээ өсөлттэй байгаа ч дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь экспортын хэмжээ буурахад нөлөөллөө. Импортын бараа бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын авто машин болон хөрөнгө оруулалтын зориулалттай импортын бараа, бүтээгдэхүүний эрэлт өссөн нь импорт нэмэгдэхэд чухал нөлөө үзүүллээ.


Уул уурхайн гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнэ буурсан нь **экспортын өсөлтөд сөргөөр** нөлөөллөө.



Хөрөнгө оруулалтын зориулалттай бараа бүтээгдэхүүний **импорт нэмэгджээ.**



Экспортын хэмжээ буурсан нь **худалдааны тэнцлийн ашиг буурахад** нөлөөллөө.




Төгрөгийн бодит ханш аажмар суларч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямд болж байна.

Төлбөрийн тэнцэл 450 сая ам.долларын алдагдалтай гарлаа.


Тээвэр, аялал жуулчлалын үнийн өсөлт нь урсгал дансны алдагдалд гол нөлөөг үзүүлжээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 65 орчим хувиар нэмэгдсэнээр санхүүгийн данс ашигтай гарчээ.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл




Инфляц аажмаар буурч, тогтворжиж байгаа нь төгрөгийн хадгаламжийн өгөөжийг нэмэгдүүлж байна.

Бодлогын хүүг оны эхэнд өсгөсөн хэдий ч хадгаламжийн хүү тогтвортой байна.

Инфляцын түвшин аажмаар буурч, тогтворжих төлөвтэй байгаа нь төгрөгийн хадгаламжийн өгөөж тогтвортой байхад нөлөөлж байна.

Хувиар




Төсвийн тэнцэл 758 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Уул уурхайн бүтээгдэхүүнээс авах татварын орлого 12.3 хувиар буурсан нь төсвийн орлого буурахад нөлөөлжээ. Урсгал зардлын өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг эзэлжээ. Үндсэн тэнцэл алдагдалтай гарч төсвийн алдагдлын дарамт нэмэгдэж байна.


Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 6 буурчээ.

ДНБ-д эзлэх хувиар




Нийт төсвийн зарлага 8.2 хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн тэнцэл алдагдалтай байна.

ДНБ-д эзлэх хувиар



Орон сууцны төрөлжсөн банк
байгуулахтай холбоотой санал



1. Хувийн хэвшилд тулгуурласан, сайн засаглалтай, шинэ банк байх;
2. Урт хугацааны хуримтлалыг дэмжсэн, байрны үнийн хөөрөгдөл үүсгэхээргүй байх;
3. Үндэсний баялгийн сангаас санхүүжүүлж буй эх үүсвэрийг зээл хэлбэрээр бус, татаас, дэмжлэг хэлбэрээр олгож хувийн эх үүсвэрийг татан оролцуулах хөшүүрэг бий болгох;
4. Оршин суугаа газраа амьдрах таатай орчин, хөршийн хамтралыг дэмжих, санхүүгийн хөшүүрэг бий болгох.

1. Хувийн хэвшилд тулгуурласан, сайн засаглалтай, шинэ банк байх.

МОНГОЛ УЛСАД ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ ХЭРЭГТЭЙ !!!



1. Хувийн хэвшилд тулгуурласан, сайн засаглалтай, шинэ банк байх.

Ипотекийн зээл Барилгын салбар Урт хугацааны дахин санхүүжилт

Арилжааны банкууд Үл хөдлөх хөрөнгө гэж юу вэ? Төв банк

Урт хугацааны хуримтлал → Урьдчилгаа төлбөр Ногоон стандартууд

Амьжиргааны доод түвшин гэж юу вэ? ТХЗ / БОНЗ / ҮХХ

ЗОРИЛТОТ Төрийн татаастай/ батлан даалттай Орон сууцны санхүүжилт:

Олон улсын санхүүгийн байгууллагууд Зохицуулалт Дангаараа / Блок
шинэ / дахин шинэчилсэн

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалсан „Стандартууд“ „Тулгуур систем“ → Холимог

„тогтвортой“ → урт/дунд/богино хугацаатай Хүн бүрт ойлгомжтой! санхүүжилт

Даатгалаар хамгаалагдсан:

„Үл хөдлөх“ → заавал дагаж мөрдөх

„Урт хугацааны зээл“

Хуримтлалтай

Эрэлт,

нийлүүлэлтэд

тохирсон

татааас

Татварын

хөнгөлөлттэй

Ажил олгогчийн

оролцоотой

2. Урт хугацааны хуримтлалыг дэмжсэн, байрны үнийн хөөрөгдөл
үүсгэхээргүй байх

Урт хугацааны хадгаламж → Урьдчилгаа төлбөр

ЗОРИЛТОТ Төрийн татаастай/ Төрийн батлан даалттай

Татварын хөнгөлөлттэй Ажил олгогчийн оролцоотой

Даатгалын хамгаалалттай:








„Үл хөдлөх“ → заавал дагаж мөрдөх зохицуулалттай

„Урт хугацааны зээл“

Хадгаламжтай

Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт

3. Үндэсний баялгийн сангаас санхүүжүүлж буй эх үүсвэрийг зээл хэлбэрээр бус, татаас, дэмжлэг хэлбэрээр олгож хувийн эх үүсвэрийг татан оролцуулах хөшүүрэг бий болгох.



4. Оршин суугаа газраа амьдрах таатай орчин, хөршийн хамтралыг дэмжих, санхүүгийн хөшүүрэг бий болгох.



Зээл

Орон сууцны сангууд
= гэрээгээр тохиролцсон санхүүжилтийн дүн

- Орон сууцны зээл (60%)
- Орон сууцна хадгаламж (40%)


Бусад боломжит сангууд: бусад хадгаламжийн, үнэт цаасны, өөрийн хөрөнгө оруулалтын г.м

Бусад гадны боломжит эх үүсвэрүүд:
Ажил олгогчийн баталгаатай зээл, төрийн дэмжлэгтэй зээл г.м

4. Оршин суугаа газраа амьдрах таатай орчин, хөршийн хамтралыг дэмжих, санхүүгийн хөшүүрэг бий болгох.



Санхүүжилтийн ерөнхий бүтэц



=100% худалдан авах үнэ

Зээл

Орон сууцны сангууд

= гэрээгээр тохиролцсон санхүүжилтийн дүн

- Орон сууцны зээл (60%)
- Орон сууцна хадгаламж (40%)

Бусад боломжит сангууд: бусад хадгаламжийн, үнэт цаасны, өөрийн хөрөнгө оруулалтын г.м



Бусад гадны боломжит эх үүсвэрүүд:

Ажил олгогчийн баталгаатай зээл, төрийн дэмжлэгтэй зээл г.м




2. Хуримтлалын хэлбэрээр дараах байдлаар хэрэгждэг байх.

Хуримтлалын хэмжээ



2. Хуримтлалын хэлбэрээр дараах байдлаар хэрэгждэг байх.



2. Хуримтлалын хэлбэрээр дараах байдлаар хэрэгждэг байх.

ГЕРМАНД: “Landesbausparkasse” → “Мужийн барилга, орон сууцжуулалтын хадгаламжийн банк”

